

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ  
БЭЛТГЭСЭН ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 05 дугаар  
сарын 06-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн  
Д.Сарангэрэл**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2015 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг тус Байнгын хороо 2015 оны 04 дүгээр сарын 28-ны болон 2015 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаараа тус тус хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийх үеэр Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр, Л.Энх-Амгалан нар аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах зардлын хувь хэмжээг бууруулах, ажлын байран дахь эрсдлийн түвшингээс хамааран зарцуулах зардлын хэмжээг тогтоох, Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан ерөнхий гүйцэтгэгчийн хүлээх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Д.Батцогт хуулийн төслийн 2 дугаар зүйлээс “4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн” гэсний дараа “малчин” гэж үг нэмж байгааг хасах зэрэг зарчмын зөрүүтэй саналыг гаргалаа.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан 2015 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар дэмжигдсэн “Аж ахуйн нэгжүүд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн олон улсын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлж байгаа бол үүнтэй холбогдон гарсан зардлыг татвар ногдуулах зардлаас хасч тооцуулах тухай” саналаа татаж авлаа.

Байнгын хорооны хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж, саналын томьёоллыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Д.БАТЦОГТ**

**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх  
зарчмын зөрүүтэй саналын томьёолол**

**Нэг.Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо  
дэмжсэн санал:**

1.Хуулийн төслийн 26.2 дахь хэсгийн “аж ахуйн нэгж, байгууллага” гэсний дараа “эрсдэлийн түвшингээс хамааран” гэж нэмэх.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр, Л.Энх-Амгалан**

2.Хуулийн төслийн 26.2 дахь хэсгийн “2.0 хувиас” гэснийг “1.5 хувиас” гэж өөрчлөх.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр, Л.Энх-Амгалан**

3.Хуулийн төслийн 28.1.17 дахь заалтын “ажил олгогч хариуцна.” гэсний дараа “Ажилтны амь нас, эрүүл мэндийн даатгалд ажилтныг даатгуулсан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан нөхөн төлбөрийг ажил олгогч олгохгүй байх үндэслэл болохгүй.” гэж нэмэх.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан, Л.Энх-Амгалан**

4.Хуулийн төслийн 28.3 дахь хэсгийн “гэрээнд тодорхой тусгана.” гэсний дараа “Хэрэв гэрээнд энэ талаар тусгаагүй бол тухайн асуудлыг ерөнхий гүйцэтгэгч хариуцна.” гэж нэмэх.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан, Л.Энх-Амгалан**

5.Хуулийн төслийн 2 дугаар зүйлээс “4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн” гэсний дараа “малчин” гэж,” гэснийг хасах.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Д.Батцогт**

**Нийгмийн бодлого, боловсрол, соёл,  
шинжлэх ухааны байнгын хороо**

---oOo---